

**БИЧИЛ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

Дугаар 2024/01-09

Улаанбаатар хот

<b>1. Зураг төсөл боловсруулах үндэслэл</b>	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/50 дугаар тушаал
<b>2. Барилга байгууламжийн байршил</b>	- Нийслэлийн 9 дүүргүүдийн нийтийн эзэмшлийн гудамж талбай
<b>3. Зориулалт хүчин чадал</b>	- Бичил цэцэрлэг хүрээлэн байгууламж <ul style="list-style-type: none"><li>• Баянзүрх дүүрэг - 4 байршил</li><li>• Сонгинохайрхан дүүрэг - 4 байршил</li><li>• Хан- уул дүүрэг - 3 байршил</li><li>• Баянгол дүүрэг - 2 байршил</li><li>• Сүхбаатар дүүрэг - 2 байршил</li><li>• Чингэлтэй дүүрэг - 2 байршил</li><li>• Багануур дүүрэг - 1 байршил</li><li>• Багахангай дүүрэг - 1 байршил</li><li>• Налайх дүүрэг - 1 байршил</li></ul>
<b>4. Төслийн иж бүрдэл</b>	Баримт бичиг иж бүрдэл: <ul style="list-style-type: none"><li>- Тайлбар бичиг</li><li>- Ажлын тоо хэмжээ</li><li>- Батлагдах /УБЗАА/</li></ul> Зураг төслийн иж бүрдэл: <ul style="list-style-type: none"><li>- Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/</li><li>- Хэмжилтын зураг</li><li>- Барилгын нэгдсэн төсөв /Магадлалын дүгнэлт/</li></ul>
<b>5. Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа</b>	Ажлын зураг төсөв нэг үе шаттай: <ul style="list-style-type: none"><li>- Зураг төсөв боловсруулж, зөвшилцөж батлуулах</li><li>- Захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндсэлэл болгоно.</li></ul>
<b>6. Арчлалт хамгаалалт</b>	Гүйцэтгэсэн ажлыг баталгаат хугацаанд өөрийн хөрөнгөөр засвар, арчлалтыг тогтмол гүйцэтгэнэ.
<b>7. Зураг төслийн байгууллага</b>	Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага
<b>8. Төслийн захиалагч</b>	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
<b>9. Хийгдэх тохижилтын ажлууд</b>	Ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэж холбогдох хүмүүстэй зөвшилцөж, төсөвт өртөг багтах хэмжээгээр ажлын зураг төсвийг боловсруулна.
<b>10. Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад</b>	<u>Төсөл хөтөлбөрүүд:</u> -Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;

<p><b>ашиглах материал</b></p>	<p>-Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал  <u>Хууль тогтоомжууд:</u>  -Газрын тухай хууль  -Барилгын тухай хууль  Норм, нормативууд:  -Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/  -Барилгын геодизийн ажил /БНБД 11-08-06/  -Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05  -Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02  -Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12  -Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм  -Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12  -Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/  -Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/  -Бусад холбогдох норм, дүрэм;  <u>Стандартууд:</u>  -Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага UCS1901B:2020  -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/;  -Хүүхдийн тоглоомын талбай эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019  - Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага UCS 1402C:2020  -Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага UCS1403C:2020  -Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага UCS 0901B:2020  - Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага UCS1403C:2020  -Бусад холбогдох стандартууд</p>
<p><b>11. Онцгой нөхцөл</b></p>	<p><u>Ажилд тавигдах шаардлага:</u>  -Тус ажилд ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол Улсын стандартад нийцсэн материал байх.  -Сагсан бөмбөгийн хашааг 4м-ээс доошгүй өндөртэй, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх. Хашааны багана, хөндлөн тулаас, тор зэргийг бат бөх материал сонгон хийж гүйцэтгэх.  -Спорт талбайн гэрэлтүүлгийг үндсэн хашаанаас тусдаа шон дээр өндөрийг тооцон хашаанаас өндөрт суурьлуулах. Гэрэлтүүлэг нь зориулалтын прожектор байна.  - Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амрах зугаалах, тохижилт бүтээн байгуулалтыг арчлах, хамгаалахад зориулж гар утас болон бусад төхөөрөмжүүдээс хянах бүхий хяналтын камерийг байршуулах  -Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг сонгохдоо гарал үүслийн гэрчилгээг хавсаргах, бэхэлгээг сайн хийж гүйцэтгэх</p>




	<p>-Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр хийх ногоон байгууламжийг төлөвлөлтийн бүсээс гаднах нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулан төлөвлөх</p> <p>-Явган зам талбайн хөдөлгөөн орц гарцыг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх</p> <p>-Гүйцэтгэлийн ажил эхлэхээс өмнө захиалагч, авторт нарт мэдэгдэж ажлын хувиарыг танилцуулах.</p> <p>-Зураг төслийг эхлэхдээ талбайд судалгаа хийж фото зураг хавсаргах, дэвсгэр зурагт заавал газар доорх инженерийн шугам сүлжээний тодруулга хийлгэх.</p>
<b>12. Эдийн засгийн тооцоо, төсөв</b>	Төсвийг ESTIMATOR-PRO программ тооцож ирүүлэх.
<b>13. Бусад</b>	Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.


**ХЯНАСАН:**

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

**БОЛОВСРУУЛСАН:**

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Г.БИЛГҮҮН

 У.САНЧИР